



60
91-09-35-01

ДАРХАН-УУЛ АЙМАГ
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ХК-ИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 99

Дархан

Журам батлах тухай

“ДДС” ТӨХК-ийн хэвийн найдвартай ажиллагаа, объектийн аюулгүй байдлыг хангасан зорилгоор компанийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалт, түүнийг хангах зорилгоор 2016.04.28-ны өдрийн 226/29 тоот албан бичгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн харуул хамгаалалтын ажил хэрэгжүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг 2016.05.16-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Дээрх журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хангамжийн хэлтсийн дарга (У.АНХБАЯР)-д хариуцуулсугай.

Хавсралт 3 хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Б.АЛТАНЦЭЦЭГ

Масмечев.

Хавсралтын хэргийн дугаар

У. АНХБАЯР.

**“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ХАРУУЛ
ХАМГААЛАЛТЫН АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1 Энэхүү журмын зорилго нь “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн харъяа албан газар, үйлдвэрийн байр, авто гараж, ил болон битүү агуулахын байр, талбай, объектуудын бүрэн бүтэн байдал, харуулд тавих хяналт, түүнийг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 2 “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-д харуул хамгаалалтын ажлыг хэрэгжүүлэгч албан тушаалтан, харуул нь өөрийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн Хууль, Ерөнхий хууль, Эрүүгийн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам болон бусад эрх зүйн актыг баримтална.

Хоёр. Нэр томъёо

- 1 Энэхүү журамд хэрэглэгдсэн нэр томъёонуудыг дор дурьдсан утгаар нэг мөр ойлгоно.
 - 1.1 “Хамгаалах объект” гэж “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн албан газар, үйлдвэрийн барилга байгууламж, авто гараж, ил болон битүү агуулахын байр, талбай түүнд агуулагдах эд хөрөнгийг
 - 1.2 “Хамгаалах хүрээ, хязгаар” гэж хамгаалж байгаа объектын нутаг дэвсгэрийн хязгаарыг тогтоосон хашаа, түүн доторхи барилга байгууламжийг
 - 1.3 “Харуулын цэг” гэж харуулын үүрэг гүйцэтгэж байгаа ажлын байрыг
 - 1.4 “Эрх бүхий албан тушаалтан” гэж “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал, Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч нарыг
 - 1.5 “Харуул” гэж харуул хамгаалалтыг шууд гардан гүйцэтгэгч ажилтанг

Гурав. Харуул хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулах

- 3.1 Объектыг гадны аливаа халдлагаас хамгаалах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор “Эрх бүхий албан тушаалтан” нь батлагдсан хуваарийн дагуу 24 цагийн турш тасралтгүй хяналтыг тогтоох, батлагдсан журмыг мөрдүүлэх, байнгын харуулыг томилж, ажиллуулна.
- 3.2 Харуул хамгаалалтын үйл ажиллагааг батлагдсан хууль тогтоомж, дүрэм, журам, “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам, Гүйцэтгэх захирлын тушаалыг удирдлага болгон тасралтгүй, шуурхай, аюулгүй зохион байгуулах, батлагдсан хуваарийн мөрдөлтөнд хяналт тавих үүргийг Хангамжийн хэлтсийн дарга хүлээнэ.
- 3.3 Харуулын ээлжийг зохион байгуулахдаа Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу зөв, бонувчтой хэлбэрээр зохицуулж, ээлжийн хуваарийг эрх бүхий ажилтнаар тухайн сарын ажлын эхний өдөрт багтаан батлуулсан байна.

4. Объектын харуул хамгаалалтыг зохион байгуулахдаа объектын байдал, даалгасан үрэг, түүнийг биелүүлэх хугацаа, объектын онцлог, үүрэг гүйцэтгэх боломж, цагдаагийн байдал, байгууллагын үйл ажиллагааны онцлог, ажлын төлөвлөгөө зэргийг үргэлжлэн үзнэ.

5. Үүрэг гүйцэтгэж байгаа харуул нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

1. Хамгаалах объектын онцлог, газар орчны байдал, түүний маршрут, "Дарханы цагдаагийн Сүлжээ" ТӨХК-ийн үйл ажиллагааны онцлог, төлөвлөгөөг судалж мэдсэн байх

2. Хамгаалж байгаа объектод тээврийн хэрэгсэл нэвтрэн орох, гарах үед тээврийн хэрэгсэл, түүний жолооч, бусад этгээд, ачаа, бусад зүйлийг шалган нэвтрүүлэх, зөвшөөрлийн бичигтэй эсэхийг лавлаж шалгах

3. Байгууллагын эрх бүхий албан тушаалтан, инженер техникийн ажилтан, албан хаагч нар, үйлчлүүлэгч иргэн, бусад хүнтэй хүндэтгэлтэй харьцах, объектод үйлдвэрийн үйл ажиллагааг таньж мэддэг байх

4. Объектод гадна, дотор талын байрлалын болон орчны нөхцөл байдалд байнга шалгалт хийж гэмт хэрэг, зөрчил гарсан тохиолдолд энэ талаар нэн даруй эрх бүхий албан тушаалтнуудад мэдэгдэх

5. Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гал түймрийн голомтоос зөөн гаргасан хөрөнгө, тоног төхөөрөмж, баримт бичиг болон бусад зүйлийг шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар хамгаалах, гадны халдлага үйлдсэн этгээдийг нэн даруй үргэлжлэн судлах, энэ талаар Цагдаагийн байгууллагад яаралтай дуудлага өгөх, туслалцаах, байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд, Хангамжийн хэлтсийн даргад утсаар мэдэгдэх, рапортын дэвтэрт энэ талаар тэмдэглэл хөтлөх

6. Объектын хашааны хаалгаар хүн, тээврийн хэрэгсэл орж, гарах боломжийг хянаж, гарц хааж автомашин тавиулахгүй байх

7. Ажил, үйлчилгээнд гарч байгаа тээврийн хэрэгслийн зөвшөөрлийн бичгийг үзэж шалгах, бараа, материал ачиж гарах тохиолдолд баримт бичгийг тулган шалгах, шаардлага гэж үзвэл Гүйцэтгэх захирал, Дэд захирал бөгөөд Ерөнхий инженерт мэдэгдэж лавлах

8. Хашааны хаалгыг онгойлгож хаахдаа цахилгаанд нэрвэгдэх, механик гэмтэлд өртөхөөс байнга болгоомжилж байна.

9. Тээврийн хэрэгслийн осолд өөрийгөө болон бусдыг өртүүлэхгүй байх талаар анхааралтай, санаачлагатай ажиллана.

10. Бороо, цас, салхи, шуургатай буюу байгалийн аюултай үзэгдлийн үед объектыг хамгаалж, тойрохдоо өөрийгөө хамгаалж, нүх сувагт унах, бэртэх, хурц үзүүртэй зүйлд өртөх, барилга байгууламжийн хажуугаар явахдаа анхаарал болгоомжтой байх, хамгаалалтанд савуулах зэрэг ослоос болгоомжилж байна.

11. Гал түймэр, аваар, үйлдвэрлэлийн осол гарсан тохиолдолд хамгаалж байгаа объектын байнгын хяналттай байлгана.

12. Ээрийн харж хамгаалж байгаа объектын цахилгааны ил монтаж, хэлхээ холбоонд өртөх, холбоо үүсэх, хэт ачаалал болох зэрэг эрсдлийг байнга анхаарч тухайн тохиолдолд илрэх бүрт байгууллагын удирдлагад мэдэгдэж засуулж байх

13. Зөвшөөрөл хамгаалалтгүй ил гал гаргах, гагнуур хийх зэрэг гал гарах зөрчлүүдийг үргэлжлэн судлах, осол тохиолдолд уг ажиллагааг яаралтай зогсоож гал унтраагуурыг ашиглаж, гал унтраагуурыг ашиглаж, Онцгой байдлын байгууллагад яаралтай мэдэгдэх

Дөрөв. Харуулд хориглох үйлдэл

- 1 Харуул дараах үйлдлийг хийхийг хориглоно. Үүнд:
- 1.1. Байгууллагын ажиллагсадтай зүй бус харьцах, барилга байгууламжийн болон өөрийн хэрэгслийн цонхны зүг өнгийж харах
 - 1.2. Харуулыг шалгах эрх бүхий албан тушаалтнаас бусад хүнд үйл ажиллагааг шилцүүлэн үзүүлэх, бусадтай зүй бус харьцах, сонор сэрэмж, хариуцлагыг сулруулах, чангаар үзүүлж чимээ гаргах, албан бус яриа биеэр болон утсаар удаан ярих
 - 1.3. Харуулын өрөөнд гадны хүн оруулах, унтах, тоглох, өөрийн ээлжинд өөр хүн оргох, архи, согтууруулах ундаа хэрэглэх, зөвшөөрөлгүй газар тамхи татах, ил задгай хаях, бусадтай маргалдах, танхайрах, шаардлагагүй тохиолдолд баримт бичиг, эд хөрөнгө, үйл дамжуулан өгөх, авах
 - 1.4. Согтуугаар ээлж хүлээлцэх, авах
 - 1.5. Зөвшөөрөлгүй хүн, тээврийн хэрэгсэл хашаанд нэвтрүүлэх
 - 1.6. Харуулын өрөөний цахилгааны монтажиг дур мэдэн өөрчлөх
 - 1.7. Харуулын үүрэг гүйцэтгэхдээ төмөр тахтай гутал өмсөх, ил гал гаргах, цахилгааны утас масслуулах, гар чийдэнгээс бусад гэрэлтүүлэг хэрэглэх

Тав. Объектын хамгаалалтын хүч нэмэгдүүлэлт

- 1 Объектын хамгаалалтыг дараах тохиолдолд хүч нэмэгдүүлнэ.
- 1.1. Гал түймэр, аваар, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн бусад аюул тохиолдож объектын хэвийн үйл ажиллагаа алдагдсан
 - 1.2. Объектод гэмт этгээд нэвтэрсэн, харуулд халдсан
 - 1.3. Объектын ойр орчимд жагсаал, цуглаан, нийтийг хамарсан эмх замбараагүй явдал үүссэн
 - 1.4. Объектын ойр орчимд гал түймэр, дэлбэрэлт, гэнэтийн бусад аюул гарсан

Зургаа. Харуулын бэлтгэл

- 1 Харуулын үүрэг гүйцэтгэхээр ээлжинд гарахдаа дараах бэлтгэлийг бүрэн хангасан байна. Үүнд:
- 1.1. Үүрэг гүйцэтгэх хугацаанд хэрэглэх хоол хүнс бэлдэж ирсэн байх
 - 1.2. Харуулын үүрэг гүйцэтгэхэд хариуцлага алдахгүйн тулд урьд өдөр нь унтаж амарсан байх
 - 1.3. Ар гэрийнхээ ажлыг зохицуулсан байх

Долоо. Хүлээлгэх хариуцлага

- 1 Энэхүү журмын биелэлтэнд Гүйцэтгэх захирал, Дэд захирал бөгөөд Ерөнхий инженер, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч, Сангамжийн хэлтсийн дарга хяналт тавьж ажиллана.
- 2 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авч шийтгэнэ.